



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 05 сарын 28 өдөр

Дугаар А/329

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Төсвийн тухай Монгол Улсын хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.4 дэх заалт, Хүүхдийн хөгжил хамгааллыг дэмжих үндэсний хөтөлбөрийн 9 дүгээр зорилтыг тус тус хэрэгжүүлэх ажлын хүрээнд аймгийн Засаг дарга, хүүхдийн төлөө зөвлөлийн дарга Б.Дүгэржавын ивээл дор зохион байгуулж буй “Инээж буй хүүхэд” аймгийн хүүхдийн нэгдсэн чуулганы зардалд 1 100 000 төгрөгийг хавсралтаар баталж зарцуулсугай.


2.Чуулганд зарцуулагдах 1 100 000 төгрөг /нэг сая нэг зуун мянган/-ийг орон нутгийн хөгжлийн сангийн 5.18-т тусгагдсан хүүхэд хамгааллын хамтарсан багийн үйл ажиллагааг дэмжих арга хэмжээнээс тооцож гаргахыг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/-д зөвшөөрсүгэй.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Б.Даваадорж/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Б.ДҮГЭРЖАВ

Аймгийн Засаг даргын 2019 оны
5 дугаар сарын 27-ны өдрийн
А/329 дүгээр захирамжийн хавсралт



“ИНЭЭЖ БУЙ ХҮҮХЭД”

ХҮҮХДИЙН НЭГДСЭН ЧУУЛГАНЫ ТӨСӨВ

№	Үйл ажиллагааны зардал	Тоо ширхэг	Нэгж үнэ /төг/	Нийт /төг/
1	Хүүхдийн жүжиг “Норовын намтар” –ыг оролцогчдод үзүүлэх	200	3000	600000
2	Дэвтэр	200	2000	400000
3	Бал	200	500	100000
	Нийт			1100000

-oOo-